



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/163/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор сум 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424 Цахим хаяг: [ganaa\\_7133@yahoo.com](mailto:ganaa_7133@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил .....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БУУЦАГААН СУМЫН БАЯНБҮРДНИЙ  
БАГА ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ш.УРАНЧИМЭГ ТАНАА

2019.02.25 № 2/86  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бууцагаан сумын Баянбүрдний бага цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Бууцагаан сумын Баянбүрдний бага цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Баянбүрдний бага цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2519158

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2.АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **2.1 Оршил**

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн эрхлэгч Ш.Уранчимэг-т танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

---

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 21-нээс 2019 оны 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: СӨБ-ын сургалтын орчны стандартын бүрдүүлэн, хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 40.8 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 0.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцсон.

### **2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Байхгүй

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Байхгүй

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 43.6 сая төгрөгийн төсөв, нэмэлт санхүүжилтээр 0.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 42.2 сая төгрөг буюу 96.9% хувьтай зарцуулж 1.3 сая төгрөгийн хэмнэлт нь хоол, цалин нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас хэмнэгдсэн байна.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс, хугацаа хоцорч, огт мэдээлээгүй мэдээлэл байхгүй шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу

материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

#### 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>11,062,585.00</u></b>	<b><u>14,151,158.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	486,992.00	96,144.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	486,992.00	96,144.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	10,575,593.00	14,055,014.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,575,593.00	14,055,014.00
35410	Бичиг хэргийн материал	52,500.00	52,500.00
35420	Аж ахуйн материал	6,487,943.00	6,487,943.00
35440	Түлш, шатах тослох материал	168,000.00	224,000.00
35460	Хүнсний материал	48,550.00	2,585,171.00
35470	Бусад хангамжийн материал	3,818,600.00	4,705,400.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>770,999.96</u></b>	<b><u>621,000.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	770,999.96	621,000.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	770,999.96	621,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,000,000.00	1,000,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.04	-1,000,000.00
39217	Ном	621,000.00	621,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>11,833,584.96</u></b>	<b><u>14,772,158.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>11,833,584.96</u></b>	<b><u>14,772,158.00</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	11,833,584.96	14,772,158.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	11,833,584.96	14,772,158.00
51210	Өмнөх үеийн үр дүн	11,833,584.96	11,833,584.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,938,573.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>11,833,584.96</u></b>	<b><u>14,772,158.00</u></b>

#### 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>33,278,500.00</b>	<b>43,794,854.60</b>

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>181,994.60</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	33,278,500.00	43,612,860.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>181,994.60</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	181,994.60
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>28,360,531.63</b>	<b>40,856,281.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,360,531.63</b>	<b>40,856,281.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>25,842,931.63</b>	<b>39,517,075.56</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>16,820,152.00</b>	<b>25,305,158.60</b>
210101	Үндсэн цалин	16,820,152.00	25,305,158.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,822,309.00</b>	<b>3,263,809.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,651,226.00	2,251,604.00
210202	Тэтгэмжийн даатгал	171,083.00	253,051.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	202,443.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	50,609.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	506,102.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,863,380.00</b>	<b>2,959,670.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,236,480.00	1,557,240.00
210302	Түлш, халаалт	626,900.00	1,119,900.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	282,530.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>359,240.00</b>
210402	Тээвэр, шатахуун	00.00	227,240.00
210404	Ном, хэвлэл	00.00	7,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	125,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,109,090.60</b>	<b>6,672,748.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	10,900.00
210502	Хоол, хүнс	5,109,090.60	6,661,848.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>21,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	21,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,000.00</b>	<b>71,450.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,000.00	71,450.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>190,000.03</b>	<b>863,999.96</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000.00	539,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	175,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,000.03	149,999.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,517,600.00</b>	<b>1,339,206.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,517,600.00</b>	<b>00.00</b>
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,517,600.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,339,206.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,339,206.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,917,968.37</b>	<b>2,938,573.04</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,917,968.37</b>	<b>2,938,573.04</b>

### 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>43,910,200.00</b>	<b>43,794,854.60</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>43,910,200.00</b>	<b>43,794,854.60</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	43,910,200.00	43,612,860.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	181,994.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	181,994.60
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>43,910,200.00</b>	<b>43,794,854.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>43,910,200.00</b>	<b>43,794,854.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>40,141,807.40</b>	<b>42,455,648.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	24,614,157.00	25,138,682.00
210101	Үндсэн цалин	19,950,357.00	20,789,639.00
210104	Урамшуулал	1,646,500.00	1,318,883.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,017,300.00	3,030,160.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,620,911.00	2,857,443.00
210201	Тэтгэврийн даатгал	2,620,911.00	2,026,790.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	204,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	170,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	11,188.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	443,965.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,147,260.00	3,147,960.00
210301	Гэрэл, цахилгаан	1,912,700.00	1,912,700.00
210302	Түлш, халаалт	1,175,900.00	1,175,900.00
210303	Цэвэр, бохир ус	58,660.00	59,360.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	227,078.00	245,100.00
210401	Бичиг хэрэг	19,600.00	21,100.00
210402	Тээвэр, шатахуун	90,000.00	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,000.00	17,200.00
210404	Ном, хэвлэл	3,878.00	11,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97,600.00	105,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,991,001.40	9,314,469.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,200.00	10,900.00
210502	Хоол, хүнс	7,230,801.40	9,198,469.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,000.00	105,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,400.00	35,900.00
210604	Урсгал засвар	33,400.00	35,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	21,000.00

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	00.00	21,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	249,300.00	253,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	249,300.00	253,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	258,700.00	1,441,994.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	174,100.00	1,369,494.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	84,600.00	72,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,768,392.60</b>	<b>1,339,206.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,717,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,517,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	50,792.60	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,792.60	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	1,339,206.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,339,206.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	11,833,584.96	00.00	11,833,584.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	11,833,584.96	00.00	11,833,584.96
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,938,573.04	00.00	2,938,573.04
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	14,772,158.00	00.00	14,772,158.00

### 1.18.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	41,479,200.00	39,794,404.00	43,612,900.00	42,273,654.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	41,479,200.00	39,794,404.00	43,612,900.00	42,273,654.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	41,479,200.00	39,794,404.00	43,589,500.00	42,273,654.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	24,848,700.00	24,564,123.00	25,263,000.00	25,138,682.00
210101	Үндсэн цалин	23,613,300.00	23,361,460.00	20,761,900.00	20,789,639.00
210102	Нэмэгдэл	1,235,400.00	740,500.00	00.00	00.00
210104	Урамшуулал	00.00	462,163.00	1,372,300.00	1,318,883.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	3,128,800.00	3,030,160.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,071,300.00	2,864,241.00	2,923,500.00	2,857,443.00
210201	Тэтгэврийн даатгал	1,954,600.00	2,864,241.00	1,949,000.00	2,026,790.00
210202	Тэтгэмжийн даатгал	223,400.00	00.00	243,600.00	204,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	279,200.00	00.00	194,900.00	170,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	55,800.00	00.00	48,700.00	11,188.00
210205	Эрүүл мэндийн даатгал	558,300.00	00.00	487,300.00	443,965.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,887,000.00	2,886,240.00	3,148,600.00	3,147,960.00
210301	Гэрэл, цахилгаан	1,912,700.00	1,912,500.00	1,912,700.00	1,912,700.00
210302	Түлш, халаалт	914,300.00	914,300.00	1,175,900.00	1,175,900.00
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	59,440.00	60,000.00	59,360.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	207,300.00	179,840.00	245,100.00	245,100.00
210401	Бичиг хэрэг	21,100.00	11,000.00	21,100.00	21,100.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	99,840.00	90,000.00	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,600.00	00.00	17,200.00	17,200.00
210404	Ном, хэвлэл	11,800.00	10,000.00	11,700.00	11,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,800.00	59,000.00	105,100.00	105,100.00
2105	<b>Нормативт зардал</b>	7,113,100.00	6,001,960.00	10,438,400.00	9,314,469.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,600.00	9,600.00	10,900.00	10,900.00
210502	Хоол, хүнс	7,103,500.00	5,992,360.00	10,322,400.00	9,198,469.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	105,100.00	105,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,600.00	43,600.00	35,900.00	35,900.00
210604	Урсгал засвар	43,600.00	43,600.00	35,900.00	35,900.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	25,100.00	21,900.00	21,900.00	21,000.00
210702	Дотоод албан томилолт	25,100.00	21,900.00	21,900.00	21,000.00

Бууцагаан сумын Баянбүрдний цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	81,600.00	81,600.00	253,100.00	253,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,600.00	81,600.00	253,100.00	253,100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3201500.00	3150900.00	1260000.00	1260000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,942,600.00	2,892,000.00	1,187,500.00	1,187,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	258,900.00	258,900.00	72,500.00	72,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	0.00	23400.00	0.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00	23,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	23,400.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	44,573,700.00	42,865,804.00	43,612,900.00	42,288,878.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	44,573,700.00	42,865,804.00	43,612,900.00	42,288,878.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	44,573,700.00	42,865,804.00	43,612,900.00	42,288,878.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00	02.00	02.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	01.00	01.00
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	28.00	20.00	28.00	23.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	28.00	20.00	28.00	23.00